



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Ажлын төлөвлөгөө батлах,  
хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, тус газрын дүрмийн 2.3, 3.2, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын орчны бүсийг нутгийн иргэдэд түшиглэсэн "байгалийн аялал жуулчлалын жишиг суурин" болгон хөгжүүлэх зорилгоор 2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан ажлуудыг төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэхийг Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/, Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/ нарт даалгасугай.


3. Төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв 1,300,000 /нэг сая гурван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 03 сарын 13 өдрийн  
А/17 тоот тушаалын нэгдүгээр хавсралт




НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРОО, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН  
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үе шат	Хугацаа	Хариуцах ажилтан
1	Налайх дүүргийн 6-р хорооны иргэдтэй уулзалт зохион байгуулах	2-р сарын 21-нд	Б.Ербахыт
2	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулах, хамгаалалтын захиргаанд албан бичгээр хүргүүлж санал авах	2-р сар / 4-р долоо хоногт /	Б.Ербахыт
3	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээ байгуулах	3-р сар /3-р долоо хоногт	Б.Ербахыт
4	"Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын жишиг суурин" төсөл боловсруулах	3, 4-р сард	Б.Ербахыт
5	Хамгаалалтын захиргааны 3-аас доошгүй байгаль хамгаалагчийг англи хэлний сургалтад хамрагдах боломжоор хангах	2-р сард	Б.Ербахыт
6	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт аялагчдад зориулсан санамж бэлтгэж хамгаалалтын захиргаанд хүргүүлэх	2-р сард	Д.Монголхүү
7	Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан үйлчилгээний гарын авлага бэлтгэх	3-р сард	Ш.Ундармаа
8	Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан үйлчилгээний гарын авлага хэвлүүлж орон нутгийн аялал жуулчлал эрхлэгчдэд хүргүүлэх	4-р сард /1, 2-р долоо хоногт /	Ш.Ундармаа
9	Нутгийн иргэд, аялал жуулчлал эрхлэгчдэд зориулсан мэргэжлийн сургалт семинар зохион байгуулах	5, 6-р сард	Ш.Ундармаа
10	Нутгийн иргэдэд түшиглэсэн спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах	3-р улиралд	Б.Ербахыт, Б.Жаргалан/
11	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт аялах явган аяллын зам тогтоох	4-р сард	Б.Ербахыт
12	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт отоглох цэгүүдийг тогтоох	5-р сард	Б.Ербахыт
13	Отоглох цэгүүдийг тохижуулах төслийн санал боловсруулах	6-р сард	Б.Ербахыт
14	Отоглох цэгүүдийг тохижуулах төслийг хамгаалалтын захиргаанд хүргүүлэх	6-р сард	Б.Ербахыт
15	Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад стандартын үзлэг явуулж, гэрчилгээжүүлэх ажлыг эхлүүлэх	Жилдээ	С.Туул

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 03 сарын 13 өдрийн  
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

A/14



НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРОО, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН  
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР  
2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Ажил үйлчилгээний нэр	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэгж зардал	Нийт зардал
1	Налайх дүүргийн иргэдтэй уулзалт зохион байгуулах /5 удаа/	Шатахууны зардал	30ш /талон/	10,000	300,000
2	Аялагчдад зориулсан санамж хэвлүүлэх	Хэвлэлтийн зардал	10.000	50	500,000
3	Сургалт зохион байгуулах /Жижиг дунд үйлдвэрлэлийн болон үйлчилгээний сургалт/	Багшийн хөлс	6	50,000	300,000
		Сургалтын материалын зардал	200	1000	200,000
	БҮГД				1,300,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
МЭРГЭЖИЛТЭН

*Б.Ербахыт*

Б.ЕРБАХЫТ

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА

-ooOoo-